



# МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН ТУШААЛ

2010 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 568

Улаанбаатар хот

## Гадаадад сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулах, тушаалд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн Газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн “Журам батлах тухай” 177 дугаар тогтоолоор батлагдсан “ Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”, Боловсрол, соёл шинжлэх ухааны сайдын 2007 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр тушаалаар батлагдсан “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам”-ыг үндэслэн ТУШААХ нь:

1. Эрдэс баялаг, эрчим хүчний яамны захиалгаар Хишигсүхийн Отгонхүүг АНУ-ын /West Virginia university/ Баруун Виржиния Их сургуулийн магистрантурт уул уурхайн боловсруулалт эдийн засгийн чиглэлээр 2 жилийн, Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгаар Цогийн Ганболдыг АНУ-ын /California International University/ Калифорнийн Олон улсын Их сургуулийн магистрантурт 2 жилийн, Боловсрол соёл шинжлэх ухааны яамны захиалгаар Болдын Батэрдэнийг АНУ-ын /Pacific States University/ Номхон далайн улсын их сургуулийн магистрантурт бизнес удирдлагын чиглэлээр 2 жилийн, Боловсрол соёл шинжлэх ухааны яамны захиалгаар Ганбаярын Отгонбаярыг АНУ-ын /Strayer University/ Стрээр Их сургуулийн магистрантурт бизнес удирдлагын чиглэлээр 2 жилийн, Боловсрол соёл шинжлэх ухааны яамны захиалгаар Цоодолын Чингүүнийг АНУ-ын /Virginia International University/ Виржиния Олон улсын их сургуулийн магистрантурт компьютер техник хангамжийн чиглэлээр 2 жилийн, Боловсрол соёл шинжлэх ухааны яамны захиалгаар Жаргалсайханы Төрболдыг АНУ-ын /University of Bridgeport/ Брижпортын их сургуулийн магистрантурт Олон улсын харилцааны чиглэлээр 2 жилийн, Сангийн яамны захиалгаар Жаргалсайханы Энхбаярыг Английн /Swansea University/ Свэнси их сургуулийн магистрантурт хүний нөөцийн удирдлагын чиглэлээр 1.5 жилийн, Эрдэс баялаг, эрчим хүчний яамны захиалгаар Эрхэмбаярын Ортүвшинг Английн /School of Business and Law/ Бизнес хуулийн сургуулийн магистрантурт уул уурхайн эдийн засгийн чиглэлээр 2 жилийн, Засгийн газрын хэрэг

475  
Тусгай  
Тусгай  
Тусгай

9  
 эрхлэх газрын захиалгаар Болдын Ундралыг АНУ-ын /Virginia International School/ Виржиниягийн олон улсын их сургуулийн магистрантурт хуулийн чиглэлээр 2 жилийн, Боловсрол соёл шинжлэх ухааны яамны захиалгаар Гандигийн Бүртэ Үжинг АНУ-ын /Strayer University/ Стрээр Их сургуулийн магистрантурт удирдлагын чиглэлээр 2 жилийн хугацаатайгаар тус тус суралцуулсугай.

2. “Гадаадад сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулах тухай” Боловсрол соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 10 сарын 29ны өдрийн 475 дугаар тушаалын 1 дүрэлбаасангийн Энхгэрэлтэй холбогдолтой хэсгийн “АНУ-ын /Lindenwood university/ Линдэнвүдийн Их сургуулийн магистрантурт Олон улсын эрх зүйн чиглэлээр 1 жил” гэснийг суралцагчийн хүсэлтээр “Австралийн /Macquarie University/ Макуайарий Их сургуулийн магистрантурт Олон улсын харилцааны чиглэлээр 2 жил” гэж өөрчилсүгэй.

3. “Гадаадад сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулах тухай” Боловсрол соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 10 сарын 29ны өдрийн 475 дугаар тушаалын Болдбаатарын Түвшинтунгалагтай холбогдолтой хэсгийн “Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яамны захиалгаар ” гэснийг “Боловсрол соёл шинжлэх ухааны яамны захиалгаар” гэж өөрчилсүгэй.

4. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан “ Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, хэргээр хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД

Ё.ОТГОНБАЯР